



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/29

Бөхт

Засаг даргын нөөцөөс хөрөнгө зарцуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний 5 дугаар хавсралтын 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны үржлийн ажлын стратеги төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээний үнийн дүнгийн 50 хувийн төлбөр 1,000,000 (нэг сая) төгрөгийг Хөдөө аж ахуйн их сургуулийн мал аж ахуй, биотехнологийн сургуулийн 5070050804 тоот дансанд шилжүүлсүгэй.

2. Дээрх зардлыг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Б.Өлзийням)-д, холбогдох санхүүгийн баримтыг бүрдүүлэхийг нярав (Т.Батбилэг) нарт даалгсугай.

ЗАСАГ ДАРГА



У.АЛТАНХҮҮ